



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/146

Ховд

Бүлэг нэмж, тусгай зөвшөөрөл олгох тухай

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 30 дугаар зүйлийн 30.1.6, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Магсаржав багт үйл ажиллагаа явуулж байгаа “Бумбагарын найзууд” цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 5 жилээр сунгасугай.

2. Жаргалант сумын Буянт багт сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа явуулж байгаа 9 дүгээр цэцэрлэгт 5 бүлэг, Баатархайрхан багт сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа явуулж байгаа 10 дугаар цэцэрлэгт 1 бүлэг, 7 дугаар цэцэрлэгийн Баатархайрхан багт үйл ажиллагаа явуулж байгаа салбар цэцэрлэгт 1 бүлэг, Жаргалан багт үйл ажиллагаа явуулж байгаа “Гэрэлтэх-Оч” цэцэрлэгийн Бичигт багт шинээр үйл ажиллагаа нээж байгаа салбар цэцэрлэгт 2 бүлгийг сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд нэмж ажиллуулсугай.

3. Цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Алтангэрэл)-д даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2017 оны А/255 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 0750

D/Zah-A/146-Bg